



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/449

Мөрөн сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."г", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 11 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 6 дугаар багийн иргэн Ц.Ганзоригт гар урлалын үйл ажиллагаа явуулахад 1150000, Мөрөн сумын Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын сургалтын зардалд 1000000, хагалгаанд ороход санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн Т.Пүрэвбаасанд 100000, эмчилгээний зардалд тусламж хүссэн иргэн Б.Буянзаяа, А.Лхагвасүрэн, Х.Амарсанаа Б.Наранчулуун Б.Батжаргал, П.Пүрэвдорж, Т.Төмөрчөдөр, гэр хүссэн иргэн М.Мөнхтуяа, Ц.Чулуун, Ц.Буянхишиг, М.Мөнхбаяр, Д.Бямбасүрэн, Д.Батцэнгэл нарт тус бүр 50000 төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх 2900000 (Хоёр сая есөн зуун мянга) төгрөгийг Засаг дарга ерөнхий дансны иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх зардлаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (С.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД